**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**Санхүүгийн аудитын баг**

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ**

**АУДИТЫН КОД: ХӨА-2021/01/СТА-ТЕЗ**

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Мөрөн 2021 он

Тэргүүлэх аудитор: О.Ганболд
Утас: 99382500 Цахим хаяг: ganboldo@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 99900662 Цахим хаяг: Baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Б.Давааням
Утас: 99629233 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх
Утас: 95908400 Цахим хаяг: Gansuhksa@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 88111896 Цахим хаяг: Mandahknaranl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: audit.mn

## АГУУЛГА

<table>
<tr><td>Тайланг бэлтгэсэн:</td><td rowspan="3">Товчилсон үгийн тайлбар<br><br>Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй<br><br>БҮЛЭГ-1 Боловсролын салбарын байгууллагуудын төсөвт зохицуулалтыг хийхдээ холбогдох хууль, журамд нийцүүлээгүй байна.<br>1.1 2020 оны төсөвт тодотгол хийж анх баталсан зорилтот түвшнийг 1,160.9 сая төгрөгөөр бууруулсан байна.<br>1.2 Боловсролын салбарын байгууллагуудын төсвийн зохицуулалтыг холбогдох хууль журмыг зөрчиж хийсэн байна.<br>БҮЛЭГ- 2 Тайлант онд орон нутгийн орлогыг 2,822.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.<br>2.1 Хөвсгөл аймгийн орон нутгийн орлого 2,822.4 сая төгрөгөөр давж биелсэн байна.<br>2.2 2.2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давсан боловч зарим орлого нэр төрлөөрөө 966.8 сая төгрөгөөр тасарсан байна.<br><br>БҮЛЭГ-3 Боловсролын салбарын байгууллагуудын батлагдсан төсөвт тодотгол, зохицуулалт хийх нэрээр байнга өөрчилж байгаа нь төсвийн сахилга бат алдагдаж, үр ашгийг бууруулж байна.<br>3.1 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл 92,6 хувьтай байна.<br>3.2 Боловсролын салбарын байгууллагуудын батлагдсан төсөвт тодотгол, зохицуулалт хийх нэрээр байнга өөрчилж байгаа нь төсвийн сахилга бат алдагдаж, үр ашгийг бууруулж байна.<br><br>Дүгнэлт:<br>Зөвлөмж:<br>Төсвийн гүйцэтгэлийн тайлан:<br>Хавсралт:<br>Холбогдох байгууллагын санал:<br>Санал өгөх тайлбар:</td></tr>
<tr><td>Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газар</td></tr>
<tr><td>Дарга, Тэргүүлэх аудитор:<br>О.Ганболд<br>Аудитын менежер:<br>Э.Бат-Эрдэнэ<br>Ахлах аудитор:<br>Б.Тэгшдэлгэр<br>Аудитор:<br>Б.Давааням<br>С.Гансүх<br>Л.Мандахнаран<br><br>2021 оны 04 дүгээр сар<br><br>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу?<br><br>Хаяг: Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр А корпус 3 давхар<br>Цахим хаяг:audit.gov.mn</td></tr>
</table>

## Товчилсон үгийн тайлбар

| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
|---|---|
| УИХ | Улсын их хурал |
| БСШУС | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд |
| БХБС | Барилга, хот байгуулалтын сайд |
| ХНХС | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТЗШ | Тусгай зориулалтын шилжүүлэг |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНӨААҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн үйлдвэрийн газар |
| СХС | Сум хөгжүүлэх сан |
| МУ | Монгол улс |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| БОАЖГ | Байгаль орчин аялал жуулчлалын газар |
| ОНХНС | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан |
| ХНХС | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| БХНСАХЗ | Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал |
| ЗГХЭГ | Засгийн газрын хэрэг эрхлэх газар |
| ГХБХБГ | Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар |
| ОНӨГ | Орон нутгийн өмчийн газар |
| БХНСАХЗ | Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал |
| БТСХ | Биеийн тамир спорт хороо |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ**
**АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 29 өдөр Дугаар А/04 Мөрөн сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/64 дүгээр тушаал, 2018 оны А/207 "Эрх үүрэг шилжүүлэх тухай" дугаар тушаал, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 3.4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар батлсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газар, Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Ш.Идэрбаясгалан)-д зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор (Б.Тэгшдэлгэр)-т үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Э.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР О.ГАНБОЛД

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй шалгуур үзүүлэлт

### *Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:*

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3.1-д тодорхойлогдсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаврын хугацаанд Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийсэн.

### *Аудитын зорилт:*

Хөвсгөл аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж дүгнэлт гарган тайлагнаж, зөвлөмж боловсруулан Хөвсгөл аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ.
Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт үндэслэлтэй эсэх
- Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийн төлөвлөгөө биелсэн эсэх
- Орон нутгийн төсвийг төлөвлөгөөний дагуу зарцуулсан эсэх
- Орон нутгийн төсвийн зарцуулалт үр дүнтэй эсэх

### *Аудитын хамрах хүрээ:*

Хөвсгөл аймгийн ТЕЗ-ын 2020 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайлан, судалгаа болон бусад баримт материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

### *Аудитын арга зүй:*

Аудитыг гүйцэтгэхдээ аудитын олон улсын стандарт, санхүүгийн аудитын гарын авлага, аймгийн Тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгосны зэрэгцээ холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

### *Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:*

Аудитад дараах хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- УСНББОУС
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2020 оны 168 дугаар тогтоол
- Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоол
- Засгийн газрын 2020 оны 187 дугаар тогтоол

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоол, 2020 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолууд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

### *Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:*

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор О.Ганболд удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ хэрэгжүүлэн, ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитор Б.Давааням, С.Гансүх, Л.Мандахнаран нар 2021 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

### *Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:*

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн болно. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

### *Үндсэн мэдээлэл:*

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагыг 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 05 дугаар тогтоолоор баталсан байна. Үүнд:

Хөвсгөл аймгийн 2020 оны орон нутгийн төсвийг анх батлахдаа татварын орлогоос 12,052.8 сая төгрөг, татварын бус орлогоос 1,721.8 сая төгрөг, хөрөнгийн орлогоос 558.5 сая төгрөг, улсын төсвийн санхүүгийн дэмжлэг 21,246.7 сая төгрөг, ОНХС-ийн шилжүүлгэээс 8,061.1 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 74,919.5 сая төгрөг нийт 123,896.5 сая төгрөгийн төсвийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Урсгал зардлын төлөвлөгөөг 110,701.0 сая төгрөгөөр хөрөнгийн зардлыг 10,730.9 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 3,886.6 сая төгрөгөөр нийт 123,896.6 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 9 дүгээр сарын 21-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор 2020 оны төсөвт 1 удаа тодотгол хийсэн байна.

Дээрх тодотголоор төсвийн төлөвлөгөөг 1,160.9 сая төгрөгөөр бууруулж 122,735.7 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэл 113,601.3 сая төгрөг буюу 92,6 хувьтай байна.

### *Аудитын явцад гарсан хүндрэл, бэрхшээл*

Аудитын явцад Монгол Улсад COVID-19 вирусийн халдвар тархсанаас холбогдох байгууллагын албан хаагчидтай биечлэн уулзах боломж хязгаарлагдмал байсан. Иймд зөвхөн нэн шаардлагатай албан хаагчтай уулзалт хийн бусад тохиолдолд онлайн хэлбэрээр ажилласан болно.

## Бүлэг 1: Боловсролын салбарын байгууллагуудын төсөвт зохицуулалт хийхдээ холбогдох хууль, журамд нийцүүлээгүй байна.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалтын дагуу тохируулсан аккруэл сууриар тайлагнасан байна.

**Баримталсан зарчим:** Хөвсгөл аймгийн 2019 оны төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл, тайлант оны санхүү, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан төсвийн орлогыг бодитой төлөвлөх, урсгал зардлын өсөлтийг хязгаарлах, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар батлагдсан Орон нутгийн төсөв боловсруулах журам болон бусад хууль тогтоомжийн хүрээнд төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг зохион байгуулах зарчимд тулгуурласан байна.

### Төсвийн төлөвлөлт

Сангийн яам нь төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагуудын төсвийн саналаас 16,554.4 сая төгрөгийг бууруулж, 31,677.3 сая төгрөгөөр 2020 оны төсвийг баталсан байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн холбогдох мэргэжилтэн Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д заасны дагуу Эрүүл мэнд, боловсролын байгууллагууд, төсвийн төвлөрүүлэн захирагчдын төсвийн төслийг хүлээн аваагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2. “сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай зориулалтын гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвхөн орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа байгууллагуудын төсвийг авч нэгтгэсэн байна. Боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагууд нь аймгийн Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газарт төсвийн төслөө хүргүүлж байна.

### 1.1 2020 оны төсөвт тодотгол хийж анх баталсан зорилтот түвшнийг 1,160.9 сая төгрөгөөр бууруулсан байна.

Хөвсгөл аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг анх боловсруулахдаа татварын орлогыг 12,052.8 сая төгрөг, татварын бус орлогыг 1,721.8 сая төгрөг, хөрөнгийн орлогыг 558.5 сая төгрөг байхаар тооцож аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан байна.

Хөвсгөл аймгийн ТЕЗ-ийн 2020 оны төсвийн зардлын анх батлагдсан төлөвлөгөөг 2019 оны гүйцэтгэл болон 2020 оны зорилтот түвшинтэй харьцуулахад дараах байдалтай байна:

*Хүснэгт -2* *//сая төг/*

| № | Үзүүлэлт | 2019 оны гүйцэтгэл | 2020 онд анх батлагдсан | Тодотго -сон | Анх батлагдсан зардлын төлөвлөгөөнөөс зөрүү | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2019 оны гүйцэтгэл | Хувь | Тодотгос он дүн | Хувь |
| 1 | Урсгал зардал | 87,400.8 | 100,701.0 | 109,233.6 | 13,300.2 | 115,2 | -8,532.6 | 0,9 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Хөрөнгийн зардал | 10,788.2 | 10,730.9 | 10,988.9 | -57.3 | 99,5 | -258.0 | 1,0 |
| 3 | Эргэж төлөгдөх цэвэр зээл | 2,566.1 | 2,464.6 | 2,513.2 | -101.5 | 96,0 | -48.5 | 1,0 |
| ***Нийт зардал*** | | **100,755.1** | **123,896.6** | **122,735.7** | **23,141.5** | **123,0** | **-1,160.9** | **1,0** |

***Хүснэгтээс харахад:*** Орон нутгийн төсвийг анх батлахдаа өмнөх оны гүйцэтгэлээс 23,141.5 сая төгрөгөөр, зорилтод түвшнээс 1,160.9 сая төгрөгөөр тус тус ихээр баталсан байна.

Аймгийн 2020 оны төсөвт Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтад заасны дагуу 1 удаа тодотгол хийсэн байна. Үүнд:

*Хүснэгт №-3* *　　　　　　　　　　/сая.төг/*

| *№* | *Үзүүлэлт* | ***2020 он*** | |
|---|---|---|---|
| | | *Анх батлагдсан* 2019.12.05-05 | *Тодотгол-1* 2020.09.21-01 |
| | Б | 1 | 2 |
| 1 | Орон нутгийн орлого | 14,333.1 | 15,324.9 |

***Тодруулбал:*** Орон нутгийн орлогыг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2020 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 991.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн тодотгол хийсэн байна.

### *1.2. Боловсролын салбарын байгууллагуудын төсвийн зохицуулалтыг холбогдох хууль журмыг зөрчиж хийсэн байна.*

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөв 70,092.2 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэл 65,885.3 сая төгрөг буюу 94 хувьтай байна.

Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 (*Төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын төсвийн зохицуулалтыг зөвхөн тухайн жилийн төсөвт тодотгол хийж шийдвэрлэнэ*), Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ыг үндэслэн аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/121 дугаар захирамжаар, 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/216 дугаар захирамжаар, 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/254 дугаар захирамжаар, 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/460 дугаар захирамжаар, 2020 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн А/597 дугаар захирамжаар тус тус 5 удаа төсөвт зохицуулалт хийсэн байна.

**Төсөвт хийсэн зохицуулалтын нийт дүнг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна:**

*Хүснэгт №-4* *　　　　　　　　　　/мян.төг/*

| Үзүүлэлт | Соёлын төв | ЕБС | СӨБ | Нийт орон нутаг | Эрүүл мэнд | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 11,685.4 | 516,762.6 | 77,879.8 | 43,379.2 | 14,489.5 | **664,196.5** |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | - | 12,355.0 | 1,478.0 | 2,725.3 | 702.0 | **17,260.3** |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 39,834.1 | 153,195.8 | 73,340.3 | 9,502.3 | 7,552.0 | **283,424.5** |
| Хангамж, бараа материалын зардал | 5,101.2 | 196,852.5 | 119,089.9 | 45,526.5 | 44,615.7 | **411,185.8** |
| Норматив зардал | 150.0 | 56,385.0 | 15,327.5 | 1,939.7 | 76,662.6 | **150,464.8** |
| Эд хогшил, урсгал засварын зардал | - | 163,541.8 | 166,155.0 | 26,356.3 | 23,226.2 | **379,279.3** |
| Томилолт, зочны зардал | - | - | 200.0 | - | - | **200.0** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 31,710.0 | 28,180.0 | 4,497.7 | 22,441.3 | **81,132.0** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 53.2 | 48,960.5 | 20,217.4 | 27,264.7 | 748.9 | **97,244.7** |
| Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 1,100.0 | 7,080.0 | 177,411.7 | 10,813.2 | - | **196,404.9** |
| Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, дэмжлэг | - | - | | - | - | **1,369.0** |
| **Дүн** | **57,923.9** | **1,186,843.2** | **679,279.6** | **172,004.9** | **190,438.2** | **2,287,858.7** |

Төсөвт хийсэн зохицуулалтыг графикаар харуулбал дараах байдалтай байна.

*График №1* *Сая.төг*




Төсөвт зохицуулалт хийсэн байдлаас харахад цалин болон нэмэгдэл урамшууллын зардалд 664.1 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 379.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 81.1 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 411.2 сая төгрөг, тогтмол зардалд 283.4 сая төгрөг, нормативд зардалд 150.5 сая төгрөгийн зохицуулалтыг тус тус хийсэн байна. Энэ нь төсвийн зарлагыг боловсруулж батлуулахдаа тогтмол зардал, эд хогшил урсгал засварын зардал, нормативд зардлын тооцооллыг бодитой төлөвлөөгүйг харуулж байна.

Тайлант онд төсөвт нийт 2,287.9 сая төгрөгийн 5 удаагийн зохицуулалт хийсэн байна. ***Тухайлбал:***

1. Ерөнхий боловсролын сургуулиудын болон хүүхдийн цэцэрлэгүүдийн төсөвт хийсэн зохицуулалтыг хянаж үзэхэд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт *“**төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах**”*-ын дагуу тооцоо судалгааг хийгээгүй, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.2-т заасан төсөвт зохицуулалт хийх шаардлага, нарийвчилсан тооцоо тайлбар хийсэн баримт бичгийг бүрдүүлээгүй, шат шатны төсөв захирагч нар саналаа ирүүлээгүй байхад зохицуулалт хийсэн байна.
2. Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан нөхцөл үүсээгүй байхад аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны 04 тоот тогтоолоор ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын

байгууллагын 2020 оны төсөвт тодотгол хийсэн байна. Энэ нь 8 сургууль, 28 цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний дүн, шат шатны ИТХ-ын тогтоолоор баталсан төсвийн дүнгээс 275.8 сая төгрөгөөр зөрүүтэй дүнгээр тайлагнасан байна. */Хавсралт №2/*

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын өмнөх жилүүдэд хийсэн санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитуудаар дээрх зөрчилтэй асуудлуудтай холбогдуулан зөрчил ариглах тухай зөвлөмж, албан шаардлагыг удаа дараа хүргүүлсэн боловч зөрчил давтагдсаар байна.

Төсвийн шууд захирагч нараас батлагдсан төсөв дотроо зохицуулалт хийх санал хүргүүлээгүй байхад төсвийн шууд захирагчийн батлагдсан төсвийг нь бууруулж, нэмэгдүүлж, мөн байгууллага хооронд зохицуулалт нэрээр хуваарилалт хийж байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1[1] , 16.5.5[2]-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь сөргөөр нөлөөлж байна. ***Иймд***: Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.1, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын холбогдох заалтуудыг зөрчин боловсролын салбарын байгууллагуудын төсөвт зохицуулалт хийж, шат шатны ИТХ-ын тогтоолоор баталсан дүнг өөрчилж байгаа холбогдох албан тушаалтнуудад хариуцлагын арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлж байна.

***Төсвийн тэнцэл = Орон нутгийн төсвийн орлого 113,608.3 сая төгрөг – Орон нутгийн төсвийн нийт зардал /113,601.3 сая төгрөг = 7.0 сая төгрөг.***

## *Бүлэг 2: Тайлант онд орон нутгийн орлогын төлөвлөгөөг 2,822.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.*

### *2.1 Хөвсгөл аймгийн орон нутгийн орлого 2,822.4 сая төгрөгөөр давж биелсэн байна.*

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн зүгээс орон нутгийн орлогын бүрдүүлэлт, татвар хураалтын ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий аймгийн Татварын хэлтэс, БОАЖГ, ГХБХБГ, ОНӨГ, Цагдаагийн газруудыг тухай бүр удирдлага зохион байгуулалтаар хангаж, тодорхой чиглэл өгч ажилласан байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу орлогыг нэр төрлөөр бүртгэн, орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг сумдын санхүүгийн албаны дарга нар, татварын байцаагчидтай сар бүр тооцоо нийлж ажилласан байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн орлогын төлөвлөгөө 2,822.4 сая төгрөгөөр давж биелсэн байна.

### *2.2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давсан боловч зарим орлого нэр төрлөөрөө 966.8 сая төгрөгөөр тасарсан байна.*

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл дараах байдалтай байна.

[1] *16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;*

[2] *16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;*

### *Төсвийн гүйцэтгэлийг санхүүжүүлэх эх үүсвэр*

*Хүснэгт №-5* *|сая.төг/*

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэлээр | 2020 он | | Гүйцэтгэл төлөвлөгөөнөөс зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | төлөвлөгөө | гүйцэтгэл | дүн | хувь |
| Дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | 1,353.4 | - | - | - | - |
| ОНХС-ийн орлогын шилжүүлэг | 8,387.2 | 7,142.8 | 6,729.9 | 412.9 | 94.2 |
| Тусгай зориулалтын шилжүүлэг | 55,848.6 | 72,826.3 | 68,520.9 | 4,305.4 | 94.1 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 31,147.9 | 35,598.9 | 35,412.2 | 296.0 | 99.2 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 440.5 | 6,437.2 | 2,220.9 | 4,107.0 | 35.1 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас | 507.9 | 730.5 | 724.3 | 6.2 | 99.2 |
| **Дүн** | **97,645.3** | **122,735.7** | **113,608.3** | **9,127.4** | **92.6** |

Төсвийн гүйцэтгэлийн санхүүжүүлэх эх үүсвэрийн гүйцэтгэлийг графикаар харуулбал:

*График №-2* *|сая.төг/*




*Тодруулбал:* Төсвийн ихэнх хэсгийг буюу 60.3 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөв, 31.2 хувийг орон нутгийн төвөөс санхүүждэг байгууллагуудын төсөв, 8.5 хувийг бусад хэсэг нь эзэлж байна.

***Орон нутгийн орлогын талаар:*** Орон нутгийн орлогын төлөвлөгөө 15,324.9 сая төгрөгөөр батлагдаж, 18,147.3 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангаж, 2,822.4 сая төгрөгөөр буюу 18.4 хувир давуулан биелүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

*Хүснэгт№-6* *|сая.төг/*

| **Үзүүлэлт** | **2020 он** | | | |
|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **Б** | 2 | 3 | 4=3-2 | 5 |
| НИЙТ ОРЛОГО | 15,324.9 | 18,147.3 | 2,822.4 | 118,4 |
| Татварын орлого | 13,009.2 | 16,531.2 | 3,522.0 | 127,0 |
| Татварын бус орлого | 1,762.2 | 1,384.0 | -378.2 | 78,5 |
| Хөрөнгийн орлого | 553.5 | 232.1 | -321.4 | 41,9 |

***Тодруулбал:*** Орон нутгийн төсвийн суурь орлого нийт дүнгээрээ давж биелсэн боловч татварын бус орлого 378.2 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 321.4 сая төгрөгөөр тус тус тасарсан хэдий ч татварын орлого 3,522.0 сая төгрөгөөр давж биелсэн нь орлого нийт дүнгээрээ давж биелэхэд нөлөөлсөн байна.

***Орон нутгийн орлого давсан шалтгаан:*** Үүнд:

1. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого давсан нь зарим сумдад ойн дагалдах баялаг болох самар их хэмжээгээр ургасан нь нөлөөлсөн.
2. Ноосны урамшууллын 10 хувийг олгосонтой холбоотой үйл ажиллагааны орлого давж биелсэн.

3. Эрдэнэс таван толгой ХК-ний иргэдэд олгосон ногдол ашгийн 10 хувийн татварыг сумдад хуваарилсан зэрэг нь орлого давж биелэхэд нөлөөлсөн.
4. Сумдын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 1.5 сая төгрөгөөс 491.4 сая төгрөгөөр давж биелсэн зэрэг нь аймгийн орон нутгийн орлогын төлөвлөгөө давахад нөлөөлсөн байна.

**Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь авч үзвэл:** Орон нутгийн орлого нийт дүнгээрээ давсан боловч 6 нэр төрлийн орлого 966.8 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Бүх сумдын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн бөгөөд Бүрэнтогтох, Их-Уул, Цэцэрлэг, Мөрөн сумдын орлогын төлөвлөгөө бүх нэр төрөл дээр бүрэн биелсэн бол бусад сумдын орлогын төлөвлөгөө 1-9 нэр төрлөөр тасарсан байна. Тариалан сумын орлого хамгийн цөөн буюу 1 нэр төрлөөр тасарсан бол Арбулаг сумын орлого хамгийн олон буюу 9 нэр төрлөөр тасарсан байна.

*Хөвсгөл аймгийн орлогын төлөвлөгөөнөөс тасарсан орлогуудыг нэр төрлөөр хүснэгтээр харуулбал:*

*Хүснэгт №-7* */сая.төг/*

| Үзүүлэлт | 2020 он | | |
|---|---|---|---|
| | Төлөв | Гүйц | Зөрүү |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 600.0 | 589.1 | -10.9 |
| Газрын дуудлага худалдаа | 354.4 | 222.6 | -131.8 |
| Ус рашааны нөөц ашигласны төлбөр | 56.0 | 38.9 | -17.1 |
| Хувьцааны ногдол ашиг | 530.9 | 58.9 | -472.0 |
| Торгуулийн орлого | 1,003.6 | 990.1 | -13.5 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 553.5 | 232.1 | -321.4 |
| **Нийт дүн** | **3,098.5** | **2,131.7** | **966.8** |

1. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 10.9 сая төгрөгөөр тасарсан нь Мөрөн нисэх буудлын үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого он дамжиж орсонтой холбоотой байна.
2. Дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар төлөвлөсөн газрын дуудлага худалдаанд оролцогч цөөн байсантай холбоотой газрын үнэ өсөөгүй, бага үнээр зарагдсантай холбоотой газрын дуудлага худалдааны орлого 131.8 сая төгрөгөөр тасарсан байна.
3. Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 17.1 сая төгрөгөөр тасарч 69.4 хувийн биелэлттэй байгаа нь COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж хөл хорио тогтоосонтой холбоотой жуулчид ирээгүйтэй холбогдуулан Номин холдинг ХХК-ийн “Сүхбаатар” хөлөг онгоц үйлчилгээнд яваагүйгээс орлого тасарсан байна.
4. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт байрлах “Могойн гол” ХК-аас экспортын зориулалтаар нүүрс худалдан борлуулахыг хориглох тухай Хөвсгөл аймгийн ИТХ-ын хуралдааны 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол гарсан, мөн дулааны үнэ тариф нэмэгдсэнээс шалтгаалсан түлш халаалтын зардал өсөж орон нутгийн өмчит компаниудын орлого буурсан, Могойн гол ХК 2020 онд орон нутгийн төсөвт 473.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 10.0 сая төгрөг төвлөрүүлсэн нь хувьцааны ногдол ашгийн орлого тасрахад нөлөөлсөн байна.
5. Хөрөнгө борлуулсны орлогын гүйцэтгэл 41.9 сая төгрөгөөр тасарсан нь тооцоо судалгаагүй орлогын төлөвлөгөөг нэмж баталсан, уурын зуухны газрыг худалдах үйл ажиллагаа хойшилсон зэрэг нь нөлөөлсөн байна.

***Орон нутгийн орлогыг бүтцээр нь харуулбал***:

Аймагт төвлөрүүлэх орлого 90.9 сая төгрөгөөр тасарч сумдын орлогын төлөвлөгөө 2,913.3 сая төгрөгөөр давж биелсэн үзүүлэлттэй байна. Үүнийг хүснэгт болон графикаар харуулбал:

*Хүснэгт №-8* */сая.төг/*

| № | Үзүүлэлт | Нийт дүн | | Зөрүү | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөв | Гүйц | | |
| 1 | Сумын төсвийн орлогын дүн | 4,912.6 | 7,826.0 | 2,913.3 | 159,3 |
| 2 | Аймгийн төсвийн орлогын дүн | 10,412.3 | 10,321.3 | -90.9 | 99,1 |
| **3** | Улсын төсвийн орлого | 4,764.0 | 5,389.6 | 625.6 | 113,1 |

*График №-3*




Улсын төсөвт төвлөрүүлэх орлого нийт дүнгээрээ 625.3 сая төгрөгөөр давж биелсэн боловч нэр төрлөөрөө 389.3 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Ковид 19 цар тахал гарсантай холбоотой ААНОАТ болон онцгой албан татварын орлого тасарснаас шалтгаалсан байна.

Орон нутгийн орлогыг гүйцэтгэлээр нь авч үзвэл орлогын 56,9 хувийг аймгийн орлого, 43,1 хувийг сумын орлого эзэлж байна.

Төсвийн орлогын төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчил дутагдал илэрч байна. ***Үүнд:***

- Түрээсийн орон сууцны эргэлтийн сан дансны төсвийг 89,4 сая төгрөгөөр төлөвлөж, 610.4 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 521.1 сая төгрөгөөр давуулсан мэт харагдаж байгаа боловч гэрээний дагуу тухайн онд төвлөрүүлэх орлогыг оновчтой ангилж, үнэн зөв төлөвлөхгүй байна.
- Улс, орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь гүйцэтгэлийг бүрэн хангуулж ажиллахгүй байгаа нь шат шатны төсөв захирагч нар нь төсвийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүйтэй холбоотой байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1[3] дэх заалттай нийцэхгүй байна.

**Сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөө гүйцэтгэлийн талаар:**

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 1,823.3 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 1,349.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 473,8 сая төгрөгөөр зээлийн эргэн төлөлтийн орлого тасарч зээлийн эргэн төлөлтөөс 74,0 хувийг бүрдүүлсэн байна. Графикаар харуулбал:

*График №3*




***Тодруулбал:*** Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөөний тасралт өмнөх онуудаас харьцангуй буурсан үзүүлэлттэй харагдаж байгаа нь хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл, зээлийн эргэн төлөлтийг бодитой төлөвлөлгүй төсвийн

3

орлогын төлөвлөгөөг боловсруулж байгаатай холбоотой байна.

*Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг үнэн зөв төлөвлөөгүй, зээлийн сонгон шалгаруулалтыг оновчтой хийхгүй байгаагаас тайлант онд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл нь төсвийн орлого бүрдүүлэлт хангагдахгүй байхад гол нөлөө үзүүлж байна.*

## Бүлэг 3: Боловсролын салбарын байгууллагуудын батлагдсан төсөвт тодотгол, зохицуулалт хийх нэрээр төсвийг байнга өөрчилж байгаа нь төсвийн сахилга бат алдагдаж, үр ашгийг бууруулж байна.

### 3.1 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл 92,6 хувьтай байна.

Хөвсгөл аймгийн 2020 оны төсвийн зарлагыг анх 123,896.6 сая төгрөгөөр баталж тодотголоор 122,735.7 сая төгрөг болгон, анхны дүнгээс 0,9 хувь буюу 1,160.9 сая төгрөгөөр бууруулсан байна. Төсвийн зардлын гүйцэтгэл 113,601.3 сая төгрөг ба өмнөх онтой харьцуулахад 13,4 хувь буюу 16,303.5 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

*Төсвийн гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар харуулбал:*

Хүснэгт №-10 /сая.төг/

| ҮЗҮҮЛЭЛТ | өмнөх оны гүйцэтгэл | Нийт | | Орон нутгийн байгууллагуудын төсөв | | Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | төлөвлөгөө | гүйцэтгэл | төлөвлөгөө | гүйцэтгэл | төлөвлөгөө | гүйцэтгэл |
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 97,297.8 | 122,735.7 | 113,601.3 | 52,643.5 | 47,716.0 | 70,092.2 | 65,885.3 |
| Урсгал зардал | 86,625.2 | 109,233.6 | 103,059.7 | 39,141.4 | 37,174.4 | 70,092.2 | 65,885.3 |
| Хөрөнгийн зардал | 9,280.2 | 10,988.9 | 9,070.4 | 10,988.9 | 9,070.4 | | |
| Эргэж төлөгдөх зээл | 1,392.4 | 2,513.2 | 1,471.2 | 2,513.2 | 1,471.2 | | |

***Хүснэгтээс харахад:*** Нийт зарлагын гүйцэтгэлийн 65,855.3 сая төгрөг буюу 58 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн зардал, 47,716.0 сая төгрөг буюу 42 хувийг орон нутгийн төсөв эзэлж байна.

Нийт зарлагын гүйцэтгэлийн 103,059.7 сая төгрөг буюу 90,7 хувийг урсгал зардал, 9,070.4 сая төгрөг буюу 8,0 хувийг хөрөнгийн зардал, 1,392.4 сая төгрөг буюу 1,3 хувийг эргэж төлөгдөх зээл тус тус эзэлж байна.

***Төсвийн зарлагын төлөвлөгөө гүйцэтгэлийг сайдын багцаар нь харуулбал:***

Хүснэгт №-11 /сая. төг/

| Д/д | Үзүүлэлт | Өмнөх оны байдлаар | Нэгтгэсэн тайлангаар | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
| 1 | ТШЗ | 32,820.6 | 41,716.6 | 36,892.6 | 88.4 |
| 2 | БСШУСС-ын ТЗШ | 54,798.0 | 70,092.2 | 65,885.3 | 94.0 |
| 3 | БХБС-ын ТЗШ | 562.7 | 638.9 | 601.3 | 94.1 |
| 4 | ХНХС-ын ТЗШ | 412.6 | 459.3 | 432.3 | 94.1 |
| 5 | Эрүүл мэндийн сайдын ТЗШ | 8,703.7 | 9,828.7 | 9,789.8 | 99.6 |
| | **Дүн** | **97,297.8** | **122,735.7** | **113,601.3** | 92.6 |

***Тодруулбал:*** Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг багцаар нь авч үзвэл 33,4 хувийг аймгийн Засаг даргын багц, 58,0 хувийг БСШУС-ын багц, 8,6 хувийг Эрүүл мэндийн сайдын багц тус тус эзэлж байна.

***Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалтын талаар:*** Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөв 70,092.2 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэл 65,885.3 сая төгрөг буюу 94.0 хувьтай байна.

***Орон нутгийн байгууллагуудын 2020 оны төсвийн зарлагын гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийг зардлын зүйл ангиар авч үзвэл:*** 2020 онд төсвийн зарлага 122,735.7 сая төгрөгөөр батлагдсан ба гүйцэтгэлээр 113,601.3 сая төгрөгийн зарлага гарч, 92,6 хувийн биелэлттэй, 9,134.4 сая төгрөгийн төсөв зарцуулагдаагүй хэмнэгдсэн байна. Үүний гол шалтгаан нь 1,041.9 сая төгрөгийн СХС-ийн зээлийг эргэлтэд оруулаагүй, Сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа хэвийн явагдаагүй зэргээс хамаарч төсвийн хэмнэлт гарсан байна.

Төсвийн жилд хэмнэлт гарсан зардлуудын шалтгаан үр дагаврыг тооцвол дараах байдалтай байна. Үүнд:

1. ***Цалин хөлс болон нэмэгдэл урамшил:*** Мөрөн, Баянзүрх, Жаргалант, Тариалан, Цэцэрлэг, Цагаан-Уул, Цагаан-Үүр зэрэг сумд цалин урамшууллын зардлын хэмнэлтийг гаргасан байна. Энэ нь Корона вирус ковид 19 цар тахлын улмаас байгууллагуудын ажилтан албан хаагчид богиносгосон цагаар ажилласан тул илүү цагийн нэмэгдэл урамшуулал тодорхой хэмжээгээр хэмнэгдсэнтэй холбоотой байна.
2. ***Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал:*** Сумдын сургууль цэцэрлэгүүд 2020 онд хөл хорионы улмаас үйл ажиллагаа нь хэвийн явагдаагүй тул гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардал нь хэмнэгдсэн бөгөөд төвлөрсөн халаалтад холбогдоогүй сумдын түлш халаалтын зардал хэмнэгдсэн зэргээс хамааран нийт 444.3 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.
3. ***Нормативд зардал:*** Нормативд зардал нийт дүнгээрээ 1,845.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд 2020 онд хүүхдийн цэцэрлэг ажиллаагүй, сургуулиуд цахимаар ажиллаж байгаатай холбоотой хоол хүнсний зардал 1,750.7 сая төгрөгөөр, Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардал 31,2 сая төгрөгөөр, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардал 63.7 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.
4. ***Эд хогшил урсгал засварын зардал:*** Эд хогшил урсгал засварын зардал нийт дүнгээрээ 766.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Энэ нь багаж хэрэгсэл, урсгал засвар, тавилга хэрэгсэл худалдан авах зардлуудын зарцуулалтын эрх нээгдээгүйтэй холбоотой байна.
5. ***Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж:*** Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 687.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой Засгийн газрын 114 дүгээр тогтоолоор цалин хөлснөөс бусад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн санхүүжилтийг түр зогсоосноос шалтгаалсан байна.
6. ***Бусад урсгал шилжүүлэг:*** Бусад урсгал шилжүүлгийн зардал 530.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь сургуулийн сурагчдын үдийн цай хөтөлбөрийн зардлаас 402.4 сая төгрөгийн хэмнэлт гарсан, тэтгэмж урамшууллын зардал хэмнэгдсэн зэргээс шалтгаалсан байна.
7. ***Хөрөнгийн зардал:*** Хөрөнгийн зардал 1,918.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХС, замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын санхүүжилт бүрэн олгогдоогүйгээс шалтгаалсан байна.

***Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчилтэй асуудлууд илэрсэн байна. Үүнд:***

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудаас Жаргалант сумын Соёлын төв 3.6 сая төгрөгөөр, Рашаант сумын ИТХ 0.3 сая төгрөгөөр, Эрдэнэбулган сумын ЗДТГ 0,2 сая төгрөгөөр нийт 4.2 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

- Аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн А/626 тоот захирамжаар “Хөгжилд хүрэх дэд бүтэц” хөтөлбөрийн санхүүжилтээс Цагаан-уул сумын Засаг даргад эрх шилжүүлсэн 100.0 сая төгрөгийг сумын Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 09-ны А/151 тоот захирамжаар “Галт дулаан” ОНӨҮГ-т шилжүүлэн улмаар “Идэр нумт” ХХК-д олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 288 тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1-т заасан үндсэн шаардлагуудыг хангахгүй байна.

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжсэн Мэргэжлийн хяналтын газрын тавилга хэрэгсэл нийлүүлэх төсөл арга хэмжээний барьцаа хөрөнгийг гэрээний дагуу 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс хойших хугацаанд чөлөөлөх байтал 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр чөлөөлсөн байна.

***Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн талаар:***

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XI хуралдааны 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар тогтоолоор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах төсөвт болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж байгууллагуудын 2020 онд худалдан авах 63,492.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2,714 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөж тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэлийг хянаж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн 2020 онд хэрэгжих 19,522.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 47 арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан бөгөөд 15,940.5 сая төгрөгийн гэрээг байгуулсан бөгөөд тендер шалгаруулалтын ажлын нийт гүйцэтгэл 87,5 хувьтай байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын болон урсгал засварын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 43,970.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2,364 арга хэмжээ батлагдсан бөгөөд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласнаар 38,628.8 сая төгрөгөөр гэрээ хийж ажилласан бөгөөд тендерийн хэмнэлт болон дараа онд шилжих арга хэмжээнүүдээс хамаарч гүйцэтгэл 99,8 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааны тайланг зохих журам зааврын дагуу бэлтгэн гаргаж сангийн сайдад аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/101 албан тоотоор хүргүүлэн ажилласан байна.

Худалдан авах ажиллагаа аймгийн хэмжээнд цахимаар зохион байгуулж хэвшсэн бөгөөд 63,492.6 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсанаас тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажилласнаар 54,569.3 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны гэрээг байгуулж, 1,394.5 сая төгрөгийн тендерийн хэмнэлтийг гаргасан байна.

***Хөрөнгө оруулалтын шинж чанартай дансны төсвийн төлөвлөлт гүйцэтгэлийн талаар:***
Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн орон нутгийн хөгжлийн сан, захиалагчийн хяналтын зардлын данс, барьцаа хөрөнгийн дансны санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийхэд дараах зөрчилтэй асуудал байна.

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын дансанд баталсан 1,736.4 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, гүйцэтгэлийг хангуулсан боловч 837.0 сая төгрөгөөр улс, орон нутгийн төсвийн байгууллагуудад автомашин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад урсгал зардлын санхүүжүүлэхэд олгосон нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна. ***Тухайлбал:*** Хөрөнгө оруулалтын шинж чанарыг агуулаагүй, төсвийн байгууллагуудын урсгал үйл ажиллагааг санхүүжүүлэх хэлбэрээр зарцуулсан байна.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2020 оны малын арьс, өлөн боловсруулах тоног төхөөрөмж /Жаргал, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сумдын/ төсөл арга хэмжээний багц-1 ажлын санхүүжилтийг олгохдоо барьцаа хөрөнгийн дансанд байршуулах 5.9 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд байршуулсан.

### 3.2 Боловсролын салбарын байгууллагуудын батлагдсан төсөвт тодотгол, зохицуулалт хийх нэрээр байнга өөрчилж байгаа нь төсвийн сахилга бат алдагдаж, үр ашгийг бууруулж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, зохицуулалт, тодотгол хийсэн нь төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байх зарчимд нийцэж байгаа эсэхэд хяналт хийсэн.

Тайлант онд ковид-19 цар тахлаас шалтгаалан сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа тодорхой хугацаанд хязгаарлалдагдсан болно. Үүнтэй холбогдуулан Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам, Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийн хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчил дутагдал илэрч байна. Үүнд:

- Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайдын 2020 оны 1а/2242 "Чиглэл хүргүүлэх тухай" албан тоотоор *“Сангийн сайдын баталсан хуваарийн дагуу цэцэрлэг ерөнхий боловсролын сургуульд хуваарилсан хоол, үдийн цайны зардлын хэмнэлтийг Боловсрол соёл, шинжлэх, ухаан, спортын яамны Төрийн сангийн 100900015902 тоот дансанд яаралтай төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллана уу “* чиглэл өгсөн байна. Дээрх чиглэлийн дагуу аймгийн хэмжээний бүх сургуулийн үдийн цай, дотуур байрны хоол, хүүхдийн цэцэрлэгийн зардал тус бүрээс **22.3** хувиар тооцож татан төвлөрүүлэх хуваарь хийсэн боловч нэр бүхийн 3 сургууль , 2 хүүхдийн цэцэрлэг нийт **86.6** сая төгрөгийг татан төвлөрүүлээгүй зарцуулсан байна. ***/Хавсралт-3/***
- Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайдын 2020.02.13 1а/864 албан тоотоор ирүүлсэн чиглэлд *“Салбарын харьяа байгууллагын хоол, үдийн цайны зардлаас хэмнэгдэж бий болсон эх үүсвэрийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс, НДШ болон тухайн байгууллагад ариутгал, цэвэрлэгээний материал худалдан авахад шаардагдах зардалд шилжүүлэх замаар төсвийн зориулалт, эдийн засгийн ангилалд зохицуулалт хийж санхүүжүүлэх“* гэсэн байхад нийт 1,899.2 сая төгрөгийг зохицуулалт хийх замаар ямар ч тооцоо судалгаагүй, хөрөнгө хэлбэрээр бэлтгэгдэж болох зардлын ангилал руу үе шаттайгаар нэмэгдүүлсэн. **/Хавсралт-3/**
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсөвт нийт 8 сургууль, 3 дотуур байр шинээр ашиглалтад орно гэж тооцон шинэ сургууль дотуур байрны

ашиглалт болон дагалдах урсгал зардалд нийт 2,114.6 сая төгрөг тусгай шилжүүлгээс баталж зарцуулах хуваарь хийж эрх олгосон байна. Үүнээс 6 том сургууль ашиглалтад ороогүй гэтэл дээрх батлагдсан санхүүжилтээс 305.4 сая төгрөгийг татан төвлөрүүлж 1,809.3 сая төгрөгийг сургуулиудад нэмж хуваарилан зарцуулсан байна.

- Бараа бүтээгдэхүүн, аж ахуйн материалын үлдэгдэл өмнөх оноос 3-4 дахин өссөн байна. Түлээ, нүүрсний зарцуулалтын норм байхгүй, аж ахуйн материал болон үндсэн хөрөнгө, хүнсний бүтээгдэхүүний зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналт сул байна.
- Сумын санхүүгийн алба нь Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8[4]-т заасны дагуу төсвийн зарцуулалт бүрийг үндэслэх баримтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс төсвийн хөрөнгө шамшигдах, хууль журмын дагуу зарцуулахгүй, үнэн зөв тайлагнахгүй байх нөхцөл байдлыг бий болгосон байна.
- Үр ашиггүй худалдан авалт хийж, бараа материалын үлдэгдлийг өсгөж байгаа ба зарим байгууллагууд нь бодитоор байхгүй хөрөнгийг бүртгэлд тусгаж, тайлагнадаг явдал газар авсаар байна. ***Тухайлбал:*** 2021 онд хэрэгжүүлсэн санхүүгийн тайлангийн аудитаар 3 байгууллага дээр 52.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон болно.

Мөн аудитаар 2021 онд ***хавсралт №3-т*** тусгагдсан байгууллагуудын холбогдох зардлыг нийт 364.8 сая төгрөгөөр бууруулж зардлыг хэмнэх боломж байна гэж үзлээ.

Дээрх зөрчлөөс харахад боловсролын салбарын байгууллагуудын төсвийн төлөвлөлт хангалтгүй, батлагдсан төсөвт тодотгол, зохицуулалт хийх нэрээр төсвийг байнга өөрчилж байгаа нь төсвийн сахилга бат алдагдаж, үр ашгийг бууруулж байна. Нөгөө талаас аймгийн болон сумдын төрийн сангийн хяналт алдагдсан байгааг харуулж байна.

***Бүтэц орон тооны талаар:*** ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын хувьд 2020 оны байдлаар нийт 5479 орон тоо баталсан бөгөөд гүйцэтгэлээр 5479 орон тоотой ажилласан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

| № | Ангилал | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | Удирдах ажилтан | 371 | 363 | -8 |
| 2 | Гүйцэтгэх ажилтан | 3,272 | 3,275 | 3 |
| 3 | Үйлчлэх ажилтан | 1,710 | 1,717 | 7 |
| 4 | Гэрээт ажилтан | 126 | 124 | -2 |
| **Дүн** | | 5,479 | 5,479 | 0 |

Нийт дүнгээр орон тоо хэтрээгүй боловч зарим байгууллагуудын хувьд орон тоо хэтэрч, хэмнэгдсэн байна. Орон тоо хэтрүүлсэн байгууллагуудыг харуулбал:

1. Тариалан сумын ерөнхий боловсролын сургууль 2 орон тоо
2. Шинэ-Идэр сумын ерөнхий боловсролын сургууль 3 орон тоо
3. Эрдэнэбулган сумын ЗДТГ 1 орон тоог тус тус хэтрүүлсэн байна.

---

[4] *Тухайн байгууллага журмын 7.5-д заасан төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг үндэслэх баримтын эх хувь, хяналтын хуудасны хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтад: урсгал зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд төсвийн захирагчийн тушаал, төсвийн задаргааг баталсан хавсралт, баталгаажуулсан цалингийн жагсаалт, товчоо, ажил, үйлчилгээ гүйцэтгэх, бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой үнэлгээний хорооны шийдвэр, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын баримт, өр төлбөр байгааг нотолсон тооцоо нийлсэн акт, жижиг мөнгөн сангийн тайлан, банк дахь бэлэн мөнгөний дансны хуулга, хөрөнгийн зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдсэн дансны хуулга болон бусад бичиг баримт хамаарна. Үндэслэх баримтын мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага хариуцна."*

Орон тоог хэтрүүлэн ажиллаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 *"эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

### 3.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн биелэлт 96,6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөвсгөл аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагыг 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр хүрэх үр дүнгийн үзүүлэлт, зорилтот түвшин, зарцуулах хөрөнгийг тооцож баталсан бөгөөд 2020 онд 1 удаагийн тодотгол хийж төсөвт өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн эрх захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг тодорхойлон нийт 26 хөтөлбөрийн хүрээнд зардлын зориулалт, арга хэмжээний ангиллаар 122,735.7 сая төгрөгийн төсөв батлагдаж, 113,601.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №-14 /сая.төг/*

| д/д | Хөтөлбөрийн нэр | төлөвлөгөө | гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Авто зам | 887.6 | 776.7 | 87.5 |
| 2 | Ангилагдаагүй бусад | 909.1 | 900.7 | 99.1 |
| 3 | Ахмад настны хөгжил хамгаалал | 63.8 | 63.8 | 100.0 |
| 4 | Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх | 860.3 | 596.6 | 69.3 |
| 5 | Биеийн тамир спорт | 502.7 | 493.6 | 98.2 |
| 6 | Газрын зураглал, кадастр | 638.9 | 601.3 | 94.1 |
| 7 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | 130.2 | 102.7 | 78.8 |
| 8 | Ерөнхий боловсрол | 51,309.3 | 48,144.9 | 93.8 |
| 9 | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих | 2,568.6 | 1,486.0 | 57.8 |
| 10 | Мал аж ахуйг хөгжүүлэх | 937.0 | 813.7 | 86.8 |
| 11 | Насан туршийн болон албан бус боловсрол | 467.2 | 454.9 | 97.4 |
| 12 | Нийгмийн халамж | 1,399.0 | 1,325.5 | 94.8 |
| 13 | Ойжуулалт | 159.6 | 156.5 | 98.1 |
| 14 | Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа | 1,817.6 | 1,760.6 | 96.9 |
| 15 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 12,684.8 | 12,206.5 | 96.2 |
| 16 | Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт | 10,231.4 | 8,423.6 | 82.3 |
| 17 | Санхүүгийн зах зээлийн зохицуулалт | 8.4 | 8.4 | 100.0 |
| 18 | Соёл урлаг | 4,037.7 | 3,942.0 | 97.6 |
| 19 | Сургуулийн өмнөх боловсрол | 20,326.0 | 18,630.7 | 91.7 |
| 20 | Суурин газрын усан хангамж | 318.8 | 318.8 | 100.0 |
| 21 | Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх | 206.4 | 200.2 | 97.0 |
| 22 | Тусгай хэрэгцээт боловсрол | 79.8 | 77.6 | 97.3 |
| 23 | Хот байгуулалт, тохижилт | 983.9 | 976.5 | 99.3 |
| 24 | Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага | 919.8 | 917.4 | 99.7 |
| 25 | Хүүхдийн хөгжил, хамгаалал | 459.2 | 432.2 | 94.1 |
| 26 | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | 9,828.7 | 9,789.8 | 99.6 |
| НИЙТ ДҮН | | **122,735.7** | **113,601.3** | **92.6** |

